

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ**  
**БАГЦ-1.**

“Монголросцветмет” ТӨҮГ-ын Улаанбаатар хот дахь захиргааны байр,  
автозогсоол, спорткомплекс 2 пост:

№	Байршил, объект	2024 он (хүн/сар)						2025 он (хүн/сар)		
		VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III
1	УБ хот Захиргаа	6	6	6	6	6	6	6	6	6

9 сарын турш ажиллах харуул хамгаалалтын ажилтны тоо: 54

1. Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: 2024-07-01 – 2025-03-31 /9 сар/
2. Үйлчилгээ үзүүлэх хуваарь: Өдөр бүр 24 цагаар

Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, “Бор-Өндөр”-ийн УБҮ: Гэрээний дагуу сар  
тутам хамгаалах харуул хамгаалалтын объект, постын тоо

№	Байршил, объект	2024 он (хүн/сар)						2025 (хүн/сар)		
		VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III
	<b>“Бор-Өндөр” УБҮ</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>27</b>
	Харуулын дарга	1	1	1	1	1	1	1	1	1
	Харуулын ахлах-жолооч	1	1	1	1	1	1	1	1	1
1	1-р пост Төв шалган нэвтрүүлэх-1	4	4	4	4	4	4	4	4	4
2	2-р пост Төв шалган нэвтрүүлэх-2	3	3	3	3	3	3	3	3	3
3	3-р пост Нефтийн төв агуулах	3	3	3	3	3	3	3	3	3
4	4-р пост МТХХ -ийн Төв агуулах	3	3	3	3	3	3	3	3	3
5	8-р пост Цэвэр усны станц	3	3	3	3	3	3	3	3	3
6	Баргилт цех 1-р пост	3	3	3	3	3	3	3	3	3
7	Баргилт цех 2-р пост	3	3	3	3	3	3	3	3	3
8	Зүүн цагаан дэлийн ТМ агуулах	3	3	3	3	3	3	3	3	3

9 сард ажиллах харуул хамгаалалтын ажилтны тоо: 243

3. Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: 2024-07-01 – 2025-03-31 / 9 сар/
4. Үйлчилгээ үзүүлэх хуваарь: Өдөр бүр 24 цагаар

Тайлбар: УБҮ-ийн төвийн постуудад ажиллах 1 жолооч, 1 автомашинтай ажиллана.

## Техникийн тодорхойлолтын хавсралт

Хавсралт А: — Үйлчилгээний

### тодорхойлолт

*Гүйцэтгэгч нь доорхи объектуудын харуул хамгаалалттай холбогдсон үйлчилгээг хариуцан ажиллана.*

*Объектуудын байрлал:*

#### **Багц-1:**

- Гүйцэтгэгч нь Улаанбаатар хот дахь төв офисын байрны харуул хамгаалалттай холбогдсон үйлчилгээг хариуцан ажиллана.*
- “Бор-Өндөр” УБҮ нь Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байрлана.*

*Хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт, гомдол шаардлага болон илэрсэн зөрчлийг цаг тухайд нь үйлдвэрийн удирдлагад мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.*

*Үйл ажиллагаатай нь холбогдуулан цагдаагийн байгууллагаас эрх зүйн хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлнэ.*

*Хамгаалалтын үйл ажиллагааг тогтмол шалгаж, архидан согтуурах асуудалтай шийдвэртэй тэмцэж, тандах багаж ашиглан илрүүлэлтийг сайжруулна.*

*Хамгаалалтанд авах объект, түүний зааг хязгаар, орон зайг зураглалаар тодорхойлон хүлээн авч хяналт тавьж ажиллана.*

*Ээлжинд гарч байгаа харуулуудын ажлыг өглөө бүр объект дээр нь харуулын ахлагчийг байлцуулан хүлээлцүүлж хэвшүүлнэ.*

*Захиалагч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон харуул хамгаалалтын журмыг хамтран хэлэлцэн баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.*

*Харуул хамгаалалтын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор сард 1-ээс доошгүй удаа харуулын бие бүрэлдэхүүнийг сэлгэн ажиллуулж байх.*

*Захиалагч талын байгууллагын нууцыг чанд хадгална.*

*Үйлдвэрийн ажилчдын хамаатан садан, уурхайн тосгонд амьдарч байгаа иргэн, урьд өмнө харуул хамгаалалтын ажилтнаар энэ үйлдвэрт ажиллаж байсан хүмүүсийг харуул хамгаалалтын ажилтнаар ажиллуулахыг хатуу хориглоно.*

*Хамгаалалтын ажилтнуудын ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйтай холбоотой бүх асуудлыг бие даан хариуцана.*

*Хамгаалалтын объект бүрд харуулын илтгэлийн дэвтрийг бэлтгэх, уг дэвтрийн хуудас бүрийг дугаарлан тэмдэг дарж баталгаажуулах, хөтөлж дууссан дэвтрийг захиалагчид хүлээлгэн өгнө.*

*Шалган нэвтрүүлэх байраар нэвтрэх хүмүүсийг согтуурал тандах багажаар шалгаж, зөрчил илрэх тохиолдолд согтуурал хэмжих багаж ашиглаж согтуурлын акт тогтоож үр дүнг харуулын илтгэлийн дэвтэрт бичиж үйлдвэрийн удирдлагад танилцуулж арга хэмжээ авахуулж байх.*

### **Хавсралт Б: — Төлбөрийн хуваарь ба Тайлан**

*Захиалагч нь тухайн сард ажилласан хамгаалагчийн тоо ажлын тайланг харгалзан 30 хоногийн дотор үйлчлэгч талд санхүүжилтийг шилжүүлнэ.*

*Захиалагч ажлын хөлсийг олгохдоо өөрийн захиргааны болон харьяа үйлдвэрүүдийн дүгнэлт, мөн үйлдвэрээс хянаж баталгаажуулсан цагийн бүртгэл, гүйцэтгэгчийн ирүүлсэн ажлын гүйцэтгэл тайланг үндэслэнэ.*

*Үйлдвэрлэлийн байдлаас шалтгаалж объект постын тоо хасагдвал санхүүжилтийг гүйцэтгэлээр тооцно. (Зөвхөн Бор-Өндөр УБҮ-ийн харуул хамгаалалтанд хамаарна)*

*Хамгаалж байгаа объектоос эд хөрөнгө алдагдсан, хамгаалалтын ажилтны сэрэмжгүй байдлаас хохирол учирсан тохиолдолд хамгаалалтын компани хариуцаж хохирлыг төлөх ба хохирлыг төлөөгүй нөхцөлд захиалагч тал гүйцэтгэгч талын хамгаалалтын хөлснөөс суутган тооцож хохирлоо барагдуулна.*

*Эд хөрөнгийн хохирлыг хоёр талаас томилогдсон магадлах комисс тогтооно.*

### **Хавсралт В: — Голлох боловсон хүчин ба туслан гүйцэтгэгчид**

*Жагсаалтад: В-1*

*Харуул хамгаалалтын ажилчид нь тусгай сургалтанд сууж гэрчилгээ авсан мэргэшсэн байх шаардлагатай.*

*Тэсрэх материалын агуулах зэрэг онц аюултай объектын хамгаалалтанд галт зэвсэг бүхий хамгаалагчид ажиллуулна. /Галт зэвсэг эзэмших эрх бүхий/(Зөвхөн Бор-Өндөр УБҮ-ийн харуул хамгаалалтанд хамаарна)*

*Харуул хамгаалалтын алба хаагчийг албан ёсоор томилж, тэдэнд гэрээнд заасан ажил үүргийг танилцуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжлийн удирдлагаар хангаж байх, дүрэмт хувцас, ялгаж тэмдэг, буу, нэг бүрийн тусгай хэрэгсэл, металл илрүүлэгч, богино долгионы радио станц, гар чийдэн болон хамгаалалтын бусад техник хэрэгслээр хангаж ажиллана.*

*Харуул хамгаалалтын алба хаагчаар эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, харуул хамгаалалтын мэргэжил эзэмшсэн, ял шийтгэлгүй хүнийг ажиллуулна.*

**Хавсралт Г: — Гэрээний үнийн Дотоод валютаар хийгдэх хэсгийн задаргаа**

*Энэ хэсэгт нийт үнийн задаргааны зардлын зүйлүүдийг жагсаах - Дотоод валютаар төлөгдөх хэсэг нь:*

- 1. Тоног төхөөрөмжийг хөлслөх эсхүл түрээслэх үнэ ханш эсхүл боловсон хүчний цалин (голлох мэргэжилтнүүд болон бусад ажилтнууд)*
- 2. Нөхөн төлөгдөх зардлууд*

*Энэ хавсралт нь зөвхөн нэмэлт үйлчилгээний хөлсийг тодорхойлоход хэрэглэгдэнэ.*

**Хавсралт Д: — Гэрээг хугацаанаас өмнө цуцлах нөхцөл,**

Захиалагч тал нь дараахь тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

- Гүйцэтгэгч тал нь удаа дараа /2-оос доошгүй удаа/ үүргээ биелүүлж чадаагүй бол,
- Хамгаалалтын албан хаагч нар үүргээ зөрчсөний улмаас захиалагч талд эд хөрөнгийн хохирол учирсан бол,
- Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын 10-аас дээш хувь нь мэргэжлийн түвшинд үүргээ гүйцэтгэж чадахгүй байна гэж үзвэл,
- Хамгаалалтын албан хаагч хулгайн гэмт хэрэгт холбогдсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдвол,
- Гүйцэтгэгч нь хамгаалалтын үүрэг гүйцэтгэх багийг техник хэрэгсэл, хүн хүч, удирдлагаар хангаж чадахгүй байгаагийн улмаас хамгаалалтын үүрэг биелэгдэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл,
- Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хамгаалалтын албан хаагчдын тоог цөөрүүлсэн бүрэлдэхүүнтэйгээр 1 сар буюу түүнээс дээш хугацаагаар хамгаалалтын үүргийг гүйцэтгэвэл.
- Гүйцэтгэгч талын гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас зогсоосон, уг зөвшөөрлийн хугацаа дууссан бол.

**Багц № 2: Шижир-Алт АҮ-ийн харуул хамгаалалт**

**"ШИЖИР-АЛТ" АҮ-Т ХАРУУЛ ХАМГААЛАЛТ АВАХ ПОСТУУДЫН СХЕМ ЗУРАГ,  
АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫН ТОО, АЖИЛЛАХ ХУВААРЬ, ГЭРЭЭТ  
ХАРУУЛ ХАМГААЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

/ТЕХНИК ТОДОРХОЙЛОЛТ, ДААЛГАВАР/

Төв аймаг, Заамар сум

2024.02.07

№	Байршил, объект	2024 он (хүн/сар)						2025 он (хүн/сар)					
		7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
1	Харуулын ахлагч	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	Эргүүл-жолооч												
3	1-р пост - Төв шалган	3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
4	2-р пост - Драг	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
5	3-р пост - Гүйцээн баяжуулах цех												
6	4-р пост - Шатахуун түгээх станц /ил уурхай/												
7	5-р пост - Усан Буу Скуббер 1												
8	6-р пост - Усан Буу Скуббер 2												
9	7-р пост - Кемп /Ил уурхай/												
10	8-р пост - Ил уурхай карьер												
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>

Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах “Шижир-Алт” АҮ-т гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх жилд ажиллах харуул хамгаалалтын ажилтны тоо 72 хүн

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: Гэрээ байгуулснаас хойш 1 жил /12 сар/

Үйлчилгээ үзүүлэх хуваарь: Өдөр бүр 24 цагаар

Өөрийн эзэмшлийн орон нутагт ажиллах тусгай тоноглолтой, бартаат зам туулах чадвар сайтай автомашин 1-ээс доошгүй, харуул хамгаалалтын ажилчдыг хөдөө уурхайн талбайд зөөвөрлөх бартаат зам туулах чадвар сайтай бага оврын автобус 1-ээс доошгүй байх шаардлагатай.